



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот


Иргэдийн бүлэг ажиллуулж, санхүүжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Монгол улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/18 дугаар тушаалын 3 дугаар хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай" 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/1016 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 2019 оны 5 дугаар хурлын тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.2-т тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан сайжруулсан түлшний хангамжийн 7 цэгт түлш савлах ажлыг тасалдалгүй үргэлжлүүлэх зорилгоор хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудтай гэрээ байгуулах замаар тус ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж буй иргэдийн бүлгийн ажилчдыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд ажиллуулах гэрээг байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т даалгасугай.

2. Иргэдийн бүлэг ажиллуулах ажлын цагийн тоо хэмжээ, цалинд шаардагдах зардлын тооцоог хавсралт ёсоор баталсугай.

3. Сайжруулсан түлшний хангамжийн 7 цэгт ажиллуулах иргэдийн бүлэг ажиллуулахад шаардагдах 200,138,400 /Хоёр зуун сая нэг зуун гучин найман мянга дөрвөн зуу/ төгрөгийг Иргэдийн бүлгийн цэвэрлэгээний зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР